



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/384

Улаанбаатар хот

## Япон Улсад багш, судлаачдыг суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан “Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам”-ын 2.7, 2.9 дэх заалт, төслийн удирдах хорооны 2015 оны 09 дугаар сарын 21-ний өдрийн 18 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн шугамаар 2015-2016 оны хичээлийн жилээс Япон Улсын их сургуулиудын магистр, доктор сургалтын хөтөлбөрт суралцуулах багш, судлаачдын нэрсийг хавсралт ёсоор баталсугай.
2. Япон Улсад суралцах багш, судлаачидтай журмын дагуу сургалтын зээлийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, Монгол улсын их сургууль /Р.Бат-эрдэнэ/, нарт тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/, Санхүү, эдийн засгийн газар /Ц.Баярхүү/, Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/, -д тус тус үүрэг болгосугай.



Л.ГАНТӨМӨР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны  
сайдын 2015 оны 09 дүгээр  
сарынх. ны өдрийн /~~14~~ дугаар  
тушаалын хавсралт

ЯПОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОР СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ 2015-2016 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС  
СУРАЛЦАХ БАГШ, СУДЛААЧДЫН НЭРС

Д/д	Эцэг, (эх)-ийн нэр, нэр	Ажиллаж буй сургууль	Япон Улсад суралцах сургууль	Суралцах хугацаа	Судалгааны чиглэл	Хамрагдах хөтөлбөр
1.	Дамдинсүрэнгийн Болортуяа	МУИС-ийн цөмийн физикийн судалгааны төвд эрдэм шинжилгээний ажилтан	Киотогийн их сургууль	3 жил	Монголын уурхай, хүрээлэн буй орчинд зориулагдсан зөөврийн рентген флуоресценцийн спектрометрийг хөгжүүлэх нь	Доктор

-----000-----